



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/540

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн 30.1.5 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А/40 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: ГХБХБГ-ын дарга

Гишүүд:
Аймгийн ИТХТэргүүлэгчдийн төлөөлөл
Сумдын Засаг дарга нар
Сумдын харъяалах багийн ИТХ-ын төлөөлөгч
ГХБХБГ-ын Мэргэжилтэн
Сумдын газрын даамал
Сумдын улсын бүртгэлийн мэргэжилтэн

2. Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгаж, тайлагнахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын зааврыг мөрдлөг болгохыг сумын Засаг нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010658

